

## **Далан жилийн түүхтэй дунд голын давсны үйлдвэр**

### ***РТМУС-ийн сэтгүүлчийн ангийн оюутан Э.Тамир***

Үдээс өмнө төлөвлөсөн ажлаа бүгдийн амжуулаад, нарантуулаас өмнөговь явах замын унаанд суулаа. хотоос 600 гаруй км засмалаар явж шөнийн гурван цагт аймгийн төвд ирэв. гэсэн хэдий ч зорьсон газраа хараахан хүрээгүй. Хэдхээн цаг дуг хийгээд үргэлжүүлэн даланзадгадаас гурвантэс явах пургонд суулаа.

Санасан зорьсон хэрэг бүтээх алтан шар зам тийшээ байна сайхан учрал, зэрэг бүрдэх аяны жолоо дээшээ байна гэж намуунхан хэрнээ цаанаа донжтой дуулсаар, замд тааралдах нүх, довыг сурамгай гэгч нь тойрох пургоны жолооч ахын дуулах чимээ дутуу нойрыг минь нөхөх шиг боллоо. жижиг тэрэг зүглэхээргүй овон товон, элс шороо ихтэй замаар 280 гаруй км зүтгүүлсээр зорьсон газрынхаа барааг харав. учрыг мэдэхгүй хүн эзэнгүй балгас уу? гэж эндүүрмээр боловч ухаад үзэхийн бол энэ газар их түүхийг өгүүлнэ. Элс шороонд дарагдаж, эзэнгүй арал шиг мартагдсан үйлдвэрийн талбай, гарын арван хуруунд багтах хэдхэн айл, хажууханд нь харагдах хуучны нэг давхар цагаан чулуун байшин, ганц цэнхэр худгаас өөр зүйл энэ тосгонд үл харагдана. Тог цахилгааны асуудал аймаг болон сумаас харьяалалгүй учраас айл болгон нэг акумлетортай. өмнө нь огт сүлжээгүй дор хаяж арав гаруй км -ын цаад ууланд гарч утсаар ярьдаг байсан бол саяхнаас мобиком, скайтел хоёроос бусад сүлжээ барьдаг болжээ. Улс орны хөгжлийг тодорхойлох үндэс нь барилга байгууламж, үйлдвэр хоршоо, зам

тээвэр, харилцаа холбоо, түүнийг дагасан хүн амын төвлөрөл, ажиллах хүч яахын аргагүй мөн билээ. Гэтэл энэ газарт нэгээхэн ч үгүй. жил ирэх тусам алслагдсаар бас мартагдсаар. Цагтаа дунд голоор дүүрэн айлууд, цаашлаад бнмау-ын давсны хэрэглээг хангадаг томоохон үйлдвэр, улаанбаатар хот руу давс тээвэрлэх ачааны том тэрэг, соёлын төв, эмнэлэг, хүүхдийн сургууль, цэцэрлэг гээд хүний хэрэгцээтэй бүхэн бүрдсэн сум байлаа. харамсалтай нь өмч хувьчлалаар эзэд нь бүгдийн буулгаад дууссан. Одоо хятадуудын барьсан хуучны цагаан чулуун байшин, элсэнд дарагдсан давсны үйлдвэр хоёр л үлдсэн. энд байгаа долоон айлын хүмүүс бүгд үйлдвэрт олон жил ажилласан хөгшчүүд, ирэн очин байдаг тэдний хүүхдүүд. Зөрөөд өнгөрөх хүмүүс дунд голд давсны үйлдвэр байсаныг тэр бүрчлэн мэдэхгүй нь харамсалтай хэмээн нутгийн хөгшчүүд хуучилна. Анх 1952 онд өмнөговь аймгийн гурвантэс сумын сондог голын урд байгуулагдсан тус үйлдвэр жилдээ 200тн -аас 2000 тн давс олборлох улсын хатуу төлөвлөгөөтэй ажиллаж байжээ. үүний дараа 1958 онд дунд голд руу нүүж, тэндээ контор, склад, улаан булан, халуун усны нэгдсэн барилгыг хятад ажилчдын хүчээр бариулан тохижиж байжээ.



Давс нь хүний өдөр тутмын хэрэглээнд зайлшгүй ордог учраас амьд биеийн чухал бүрэлдэхүүн хэсэгт тооцогддог. Ялангуяа манайх шиг давсны хэрэглээ өндөр улсад энэ сэдвийг тойрч гарахын эцэсгүй. Фосфорын хүчлийн кальци, давсны хүчлийн натри, кали зэрэг нь хүний биед орших давсны гол хэсэг болдог. Насанд хүрсэн хүний биед 3 кг орчим янз бүрийн давс байдаг. Ясны бүрэлдэхүүнд фосфорын хүчлийн кальци орж, түүний хатуу бат бэх чанарыг бий болгодог. Давсны усан уусмал бие махбодын дотор явагдах химийн урвалын орчин болдог бөгөөд, эд эсийн амьдралд чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг мэргэжлийн эмч нар хэлнэ. Хоолны давс хүн төрөлхтөнд хичнээн чухал зүйл болох нь хамгийн энгийн жишээн дээр харагддаг. Монголчууд сэтгэл нийцсэн зүйлээ “давс нь таарч” гэдэг бол хэтрүүлэгтэй яриаг “давсыг нь ихдүүлэх” гэж ярьдаг. харин оросууд хамгийн хүндтэй зочиноо талхан дээр давс тавьж угтдаг бол төвд болон африкийн олон оронд давс мөнгөн тэмдэгтийн үүрэг гүйцэтгэж байсан тухай түүхэнд тэмдэглэгдэн үлджээ.



Монголчууд анхнаасаа гаднаас давсаа гуйдаг ард түмэн байгаагүй. Одоогоор дунд голд давсны үйлдвэр байсныг нотлох хоёрхон баримт байна. Нэгдүгээрт өмнөговь аймгийн төрийн архив, хоёрдугаарт үйлдвэр ажиллаж байх үеийн ажилчид болон тэр үеийн хүмүүс. гурвантэс сум нь баруун, зүүн, дунд гэсэн тэгшийн гурван голтой. үүний нэг болох дунд голоос одоог хүртэл цагаан, хөх, улаан давс гардаг. Нийт талбайн хэмжээ нь 2.2 км<sup>2</sup> ба ашиглах зориулалтаар нь хүнсний, техникийн, тэжээлийн гэсэн үндсэн гурван төрлийн давс гардаг. 1987 оноос хойш өнөөдрийг хүртэл тус үйлдвэрт ажиллаж байгаа цэрэндоржийн лхүмбэтэй ярилцлаа. Тэрээр энэ нутагт төрж, өссөн уугуул хүн төдийгүй түүний аав, ах хоёр мөн энэ үйлдвэрт олон жил ажиллажээ.

*Дунд голын давсны үйлдвэрт одоо тавхан хүн л ажиллаж байна. үүний гурав нь эмэгтэй. Ажиллаж байгаа хүмүүс бүгд тэтгэвэрийн насныхан. Саяхан гэхэд хөрш айлын хүн 80 хүрээд, хөл гар муудаад ажилахаа больсон.*

**- Таныг зорьж ирэх хувь хүмүүс их гэж сонссон. Үүнээс гадна жижиг дунд үйлдвэрүүд хэр их давс авдаг вэ?**

*- Зуны дэлгэр цагт хүмүүс их ирдэг. миний мэдэхийн дунд голын шаврыг үе мөчид хэрэглэхэд сайн гэж манай хөгшчүүд ярьдаг. Гэхдээ нарийн сайн судалсан үгүйг нь мэдэхгүй л байна. Давсны дэлэн мал хужирлахад сайн болохоор энэ голоос авах юм их шүү. Ер нь хот хөдөөгийн арьс ширний үйлдвэрүүдээс цагаан давсны захилга их*

өгдөг. Хуучин үйлдвэр ажиллаад хүн хүч их байхад нэг үйлдвэр битгий хэл нилээд хэд рүү нь хэдэн мянган тонноор нь давсаа зөөдөг байлаа. Энэ жил бороо хур бага орсон болохоор цагаан давс өмнөхөө бодвол бага гарч байна. Бас их хэмжээний захиалга авахаар хангалттай ажиллах хүчингүй байна. Одоогоор “сондог давс”-ны цех жилд дунджаар 60-70 тн цагаан давс, Өвөрхангай аймгийн давс борлуулдаг хувь хүн 6-7тн хөх давсыг тогтмол авдаг.

**-Давсыг гар аргаар олборлоход ажиллах хүч хэрэгтэй шүү дээ? Одоо хэдэн хүн энэ үйлдвэрт ажиллаж байгаа бол?**

-Энэ их амаргүй ажил. Эхлээд давсны дэлэнг хуулж шинэ тогоо гаргана. дэлэнгийн доор нь байгаа шаврыг ямар нэгэн техникээр биш өөрсдийн цэвэр мэдрэмжээрээ ухаж гаргадаг. Хэрвээ шавраа хүчтэй ухвал эхлээд гарах хөх давсаа шавартай нь холих аюултай учраас болгоомжтой ухна. Үүний дараа хөх давсаа ханасан уусмалд угаагаад гаргадаг. Өөрөөр хэлбэл хөх давсаа авсаны дараагаар цагаан давсыг авдаг. Сүүлийн жилүүдэд элсний нүүдэл болон бороо хур их орж байгаа. Бид нар шиг хамаг ажлаа гараараа хийдэг хүмүүст энэ нь ажлыг улам нэмэгдүүлнэ. Угааж цэвэрлэсэн давсаа 2-3 хоног хатааж шуудайлахдаа амыг нь оёж дугуйгаар машин руу зөөнө. Бороо орсон үед шавар ихтэй болохоор дугуй битгий хэл хөөлөөрөө явахад хэцүү. Одоо дунд голын давсны үйлдвэрт ердөө тавхан хүн л ажиллаж байна. Үүний гурав нь эмэгтэй. Бүгд тэтгэврийн насныхан. Саяхан хөрш айлын хүн 80 хүрээд, хөл гар муудаад ажилахаа больсон. Залуучууд хотоос ирээд сар хүрэхгүй ажиллавал их юм. Хүний хөдөлмөрийг хөнгөвчлөх зүйлгүй бүх ажил гар аргаар хийгддэг хүнд хүчир болохоор залуу хүн тогтохгүй байх нь аргагүй биз дээ. Бас манай эндхийн зам

*их муу, том хэрэг жилдээ дээд тал нэг удаа ирж 10 тн давс авна. Сүүлийн хэдэн жил манай ийшээ засмал зам тавигдаж байгаа. Сонгууль дөхөхөөр хүмүүс хааяа нэг ирнэ. сүүлд гэхэд давсаа хураах агуулах барьж өгнө, засмалаа үргэлжүүлээд тавих амлалт өгсөн. Нэг үеэ бодвол хөгжиж л байгаа юм. гэхдээ дахиад хэдэн жил энэ хэвээр үргэлжлэхийг хэлж мэдэхгүй байна.*



*1974 оны үерэр давсны үйлдвэрийн талбай усанд автаж ажиллах аргагүй болж гурван жил нам зогссон. Тухайн үед ажиллаж байсан хүмүүс олноороо аймаг руу явж энд хэдхэн айл үлдсэн. Өмнө ч тэр одоо ч тэр давсыг гар аргаар үйлдвэрлэдэг болохоор давсны талбай элсэнд дарагдах, бороо хур их орох, эсвэл огт орохгүй байхаас шалтгаалж зарим жил бид өмнөхөөсөө хоёр дахин илүү хөдөлмөрлөг.*

**-Бүх ажлаа гараар хийдэг ч үүнд арга технологи гэж байдаг байх?**

**Энэ талаар**

- Одооны хүмүүс хүнд хүчир ажлаас аль болох татгалздаг болсон. Аргайгүй дээ, нийгэм өөрчлөгдөөд хүний эдэлж хэрэглэж байгаа бүхэн хөдөлмөр хөнгөвчилсэн сайхан цаг шүү дээ. Гэхдээ бид хүнд хэцүү гээд энэ их баялагаа орхиж болохгүй. Давсны үйлдвэр ажиллаж байхад тухайн үеийн хүмүүс энэ талбайд техникийн тусламжтайгаар давс авах гэж үзсэн. Гэсэн хэдий ч ажилттай болж чадаагүй. Миний бодлоор энд эрчим хүчний эх үүсвэртэй болвол хагас механикжсан төхөөрөмж ажиллах боломжтой. Тэгвэл илүү хурдан бас хялбар ажиллана. Би ч энэ голынхоо буянаар долоон хүүхдээ хүний гар харлуулалгүй бүгдийн их дээд сургууль төгсгөсөн. Одоо нас яваад давсаа нэг нэг шуудайгаар нь зөөж байна даа. Дунд голын давсны үйлдвэр ажиллаж байхад хүн хүч их байлаа. Ажиллах нөхцөл хүнд болохоор хүмүүс хөдөлмөрлөсөн хэмжээгээр цалинждаг.

Социализмын үед давсны үйлдвэр одоогийн уул уурхай шиг хамгийн өндөр цалинтайд тооцогддог байлаа.

Давсны талбайд сүүлийн жилүүдэд цөлжилт их явагдаж байгаагаас үүдэн элсэнд дарагдаж, хүний хөдөлмөрийг хөнгөвчлөх нэг ч ажил байхгүй учир давс олборлоход маш хэцүү нөхцөл байдалд хүрсэнийг тэрээр хэллээ. Давс гаргах үйл явц бүгд гар ажиллагаагаар хийгддэг. тогооноос гарсан шавартай давсыг эхлээд ханасан уусмалд цэвэрлээд, хүрздэж гарна. Давсыг чийгтэй байлгаж болгохгүй учраас тэндээ хоёр хоног хатаагаад шуудайд хийж, эрэг рүү зөөнө. Өдөржингөө урт түрийтэй усны хар гутал, битүү хувцастай, халуун наранд ханасан уусмалаас давс гаргаж, эрэг рүү үүрч эсвэл унадаг дугуйгаар зөөнө гэдэг

тийм ч амар ажил биш байх. хуучин давсны үйлдвэрийн ажилчдыг хүнд, хортой нөхцөл гэж үздэг байсаныг сүүлд хэвийн нөхцөл болгожээ. Гэтэл бодит байдал дээр давс олборлоход хөдөлмөр хөнгөвчилж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх тоног төхөөрөмж битгий хэл тог цахилгааны асуудал одоог хүртэл шийдэгдээгүй байна.



Дунд голын давсны үйлдвэртэй холбоотой мэдээлэл манай улсын архивын ерөнхий газар болон улсын бүртгэлд байдаггүй. Учир нь үйлдвэр анх байгуулагдахдаа аймаг орон нутгийн нэгдэл, хоршоолол, үйлдвэрийн алдагдлыг нөхөж ажиллаж байх үеийн баримт бичгүүд байдаг болохоос яг дунд голын давсны үйлдвэр гэсэн тусдаа хавтастай материал байдаггүй. Тодруулбал тус үйлдвэр 1952-1971 онд өмнөговь аймгийн үйлдвэр хоршоолол, 1972-1990 онд хүнсний үйлдвэрлэл, 1981-1990 онд хонгорын голын хоршоолол, 1990-1992 онд гурвантэс сумын



“соёл” нэгдэлд харьялагдаж байсан. Цагаан давсаар арьс түүхий эд давслах, хөх давсыг хоол унданд хэрэглэх, давсны дэлэнг мал хужирлахад ашиглаад зогсохгүй мах комбинат, арьс ширний үйлдвэр, цахилгаан станцуудад давсаа нийлүүдэг ашиг орлого, амт чанар сайтай нэрд гарсан үйлдвэрлэл байжээ. Мөн одоогоор тухайн үйлдвэрт ажиллаж байсан хүмүүс, тэдний хүүхдүүд лавлагаа авах гэж архивт ханддаг болохоос давсны асуудалд анхаарч, судаалгаа хийж, материалуудтай танилцсан анхны тохиолдол энэ болохыг тус аймгийн архивын дарга Ө.Учрал онцоллоо. Мөн тэрээр өмч хувьчлалаас хойш дунд голын давсны үйлдвэртэй холбоотой мэдээлэл өмнөговь аймгийн архивт огт байхгүй. Архив төрийн байгууллага учраас хувийн хэвшлийн байгууллагуудын мэдээлийг өөрсдөө зөвшөөрөөгүй тохиолдолд авах эрхгүй болохыг хэллээ. Өмч хувьчлалын үед дунд голын давсны үйлдвэрийг 1991 онд өмнөговь аймгийн “соёл нэгдэл” ххк, 1994 онд “чандмань” компани, “молор давс” ххк, зэрэг байгууллагууд үйл ажиллагаа явуулж байсан бол одоо “сондог давс”-ны цех дунд голоос давсаа авч, үйлдвэрийн аргаар савлаж улаанбаатар болон аймгуудад борлуулдаг. “Сондог давс”-ны цех нь дунд голын давсны үйлдвэрийн талбайн 28 га-г эзэмшдэг ба тэндхийн давс хлорт натрийн агууламж 97%, иодын хэмжээ 29%-тай үйлдвэрлэл явуулахад тохиромжтой болох нь магадлан итгэмжлэгдсэн “эко стандарт” лабораторийн шинжилгээгээр батлагджээ.

Монголд давс олборлодог газар ганцхан өмнөговь аймгаар дуусахгүй ээ. Тодруулбал улсын хэмжээнд тогтмол үйл ажиллагаа явуулдаг хүнсний давсны голлох дөрвөн орд байдаг. Үүнд увс аймгийн шүдэн уул, завхан аймгийн дэвтээр, өмнөговь аймгийн дунд гол, дорнод аймгийн сангийн далай зэрэг орд гарзууд багтана. Үүнийг “давсны

сумьяа” нэрээр алдаршсан аж үйлдвэрийн гавьяат ажилтан, инженер, ахмад геологич ж.сумьяа 20 гаруй жил эх орныхоо эрдэс давсыг судалж 100 орчим давсны ордыг илрүүлж, улсын хэмжээнд давсжилт бүхий 13 ай савыг 30 дэд хэсэгтэйгээр ялган, нөөцийг нь тогтоожээ.

## Монгол улсын хүнсний давсны гол ордууд



Тэрээр 2011 онд гаргасан “Монгол орны давсны нөөц баялаг” номондоо төрийн зүгээс давсны салбарт зайлшгүй анхаарах хэд хэдэн асуудлыг бичжээ. Үүнд:

**Нэг:** Манай улс байгалийн давсны нөөц баялаг /девоны чулуун давс, неогены давс агуулсан хурдас, нуурын давсны ордууд /-тай боловч тэдгээрийг түшиглэсэн давс боловсруулах буюу давсны химийн жижиг дунд үйлдвэрлэл хөгжиж чадахгүй байгаа нь тэр талын дагнасан мэргэжилтэн хомс, давсны үйлдвэрлэлийн олон талын бодлогогүй, орон нутагт зохицох техник-эдийн засгийн үндэслэл тооцоогүй, мэдээлэл сэтгэлгээний хоцрогдол, хөрөнгө оруулалт, байгаль цаг уурын эрс тэс нөхцөл, цахилгаан эрчим хүч, уур дулааны хангамж, шатах тослох материал, үнийн өсөлт, хил гаалийн асуудал болон бусад татварын дарамт гэх мэт олон хүчин зүйл нөлөөлж байна.

**Хоёр:** Хүнсний давс стратегийн бүтээгдэхүүн байдаг учир энэ төрлийн ордыг стратегийн ордод оруулж “ ашигт малтмалын тухай “хуульд тусгах

**Гурав:** Өнөөгийн байдлаар үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй олон тооны аж ахуй нэгжүүд давсны үйлдвэрлэл явуулж байгаа боловч чиглэл тодорхойгүй, хараа хяналтгүй өөрөөр хэлбэл төрийн зохицуулалтгүй учир чанаргүй, хуурамч бүтээгдэхүүн хийж ашиг хонжоо олох, нийгэм амь насанд халтай явдал хэт хавтгайрсан байна.

**Дөрөв:** Зүй зохисгүй олборлолтоос болж давсыг шавартай нь ашиглах боломжгүй болгосон орд газрыг хэвийн болгож болгохын зэрэгцээ давсыг нь бас ашиглаж болох арга зам бий. үүнд шавраар бохирдсон давсыг уусмал болон байгалийн аргаар шүүн тунгаан уусмалаа орд газарт нь буцаан хийнэ. харин шаварлаг хэсгээр нь орд газрын зах хөвөөгөөр далан хийж, хиймэл тогоо болгон ашиглана. ийнхүү устгагдсан баялгаа арвижуулан, байгалийн нөөцийг үлэмжээр бий болгоно. Тухайлбал ой модгүй газрыг ой модтой болгох гэх мэт идэвх санаачилгатай үйл ажиллагааг төрөөс дэмжиж, шагнал, соёрхлоо түүн лүү олгох нь шагналын утгыг шинэ эзэдтэй болгох нийгмийн шаардлага

гарч байна гэжээ. Мөн 2017 онд монголын геологийн холбооноос “Монгол орныхоо давсны үйлдвэрлэгчдийнхээ өрсөлдөх чадварыг төрөөс хамгаалж, хөхүүлэн дэмжихийг уриалан, монголын геологийн холбоо давс, мөсөн шүүний хайгуул, үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдтэй хамтарч засгийн газар, уухүя, боажнхя-д хүсэлт хүргүүлэн хамтарч ажилахаа мэдэгдсэн. Тус холбооноос гаргасан судалгаанд “ Монгол орны давс, мөсөн шүүний жилийн нийт хэрэглээ 20 мян.тн ба 16 тэрбум төгрөг байна. Үүнээс үндэсний давс үйлдвэрлэгчид жилд дөнгөж 2-3 мян.тн давс зах зээлд нийлүүлдэг. Монголд нэг хүн жилд дунджаар 5-6 кг хоолны давсыг хүнсний хэрэглээнд хэрэглэдэг гэж тооцоход монгол улсын хоёр сая хүн ойролцоогоор 10 мян.тн буюу 8 тэрбум төгрөгөөр хоолны давс худалдан авч хэрэглэдэг. цахилгаан станцууд усаа зөөлрүүлэх, цэвэршүүлэх зорилгоор жилд гурван мян.тн, уб хотын дүүргүүд замын халтиргаа, гулгаа арилгах зориулалтаар таван мян.тн, бусад малын тэжээл, арьс ширний үйлдвэрт ашиглаж байна. Монгол орныг зөвхөн зургаан давсны орд, мөсөн шүүний нөөцөөр дотоодынхоо хэрэглээг 3500 жил хангах бүрэн боломжтой” гэжээ. 2021 онд манай улсын хүнсний давсны 97% хувийг импортын давс эзэлсэн талаар энэ оны тавдугаар сард eagle телевиз мэдээллэсэн. Үүнтэй холбоотойгоор гаалийн ерөнхий газраас авсан сүүлийн үеийн тоо баримтыг танилцуулья.

мянган ам.доллар/ thous. USD		Хавсралт №5 / Appendix №5		
Барааны код	Барааны нэр	Хэмжих нэгж	First 10 months Эхний 10 сар	
			Тоо Quantity	Үнэ Amount
25010011	<b>Иоджуулсан давс</b>	кг	<b>3,811,760.0</b>	<b>1,010.7</b>
	Австри	кг	6,219.6	10.9
	Америкийн Нэгдсэн Улс	кг	15,739.9	18.5
	Беларусь	кг	127.0	0.1
	БНСУ	кг	15,309.7	20.4
	<b>БНХАУ</b>	<b>кг</b>	<b>1,962,600.0</b>	<b>228.1</b>
	Испани	кг	18,610.0	12.7
	Итали	кг	37.3	0.2
	Малайз	кг	226.8	0.7
	ОХУ	кг	887,728.9	146.9
	Пакистан	кг	38,083.2	18.9
	Тайланд	кг	7,939.0	20.6
	Турк Улс	кг	59,067.8	55.5
	Франц	кг	966.0	1.7
	ХБНГУ	кг	791,619.3	468.3
	Япон	кг	989.5	1.7
25010019	<b>Бусад давс</b>	<b>кг</b>	<b>4,604,900.7</b>	<b>745.0</b>

## Гаалийн ерөнхий газраас энэ оны 10 сард гаргасан импортын иоджуулсан давсны тоон үзүүлэлт

Манай улс давсны ордуудаа эрчим хүчний эх үүсвэртэй болгох, үйлдвэрлэлийг механикжуулах техник технологийн импорт болон жижиг дунд үйлдвэрүүдийн бодлогыг дэмжиж ажиллавал гаднаас давсаа гуйх шаардлагагүй, байгаа нөөцөөрөө дотоодын хүнсний давсны хэрэглээг хангах бүрэн боломжтой талаар ххаая-нд хүнсний газрын мэргэжилтэн, /1996-2010 он/ “иод дутлын эмгэгтэй тэмцэх үндэсний хөтөлбө”-рийн зохицуулагч, 1999 оны “хүнсний тухай” хуулийн шинэчилсэн найрууллагаар давсыг стратегийн бүтээгдэхүүнд оруулах багийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан, монголын давс үйлдвэрлэгчдийн холбооны тэргүүн асан хүнсний технологич, инженер Ц.Бат-эрдэнэтэй ярилцлаа.



**-Манай улс асар их давсны нөөцтэй орон шүү дээ. гэвч үүнийг ашиглах тоног төхөөрөмж, ажиллах хүч хомс байна. Таны бодлоор үнийг яаж шийдвэл үр дүнтэй вэ?**

- Монголчууд дотоодынхоо давсны хэрэгцээг хангах бүрэн боломжтой болох нь маш олон судалгаагаар батлагдсан. Одоогоор нөөцөө хангалттай ашиглаж чадахгүй байгаад хэд хэдэн хүчин зүйл нөлөөлнө. Жишээ нь монголд байгаа зарим давсыг импортын давстай харьцуулахад өнгөний хувьд бор байдаг. Энэ нь давсыг цэвэрлэх тоног төхөөрөмж хомс, хүний хөдөлмөрөөс ангижраагүй, ямар нэгэн үйлдвэрийн шат дамжлага байхгүйн тод жишээ. дараагаар нь ажиллах хүчний асуудал. Давсны олборлолт байгаль цаг уураас хараат болохоор хавар, намрын улиралд давс авахад хамгийн тохиромжтой гэж үздэг. өөрөөр хэлбэл хавар мал төллөж, ноос ноолуураа авдаг бол намар ургац хураалт, хадлан хадах, өвөлжилтийн бэлтгэл гээд энэ бүх ажилтай давсны олборлолт давхцдаг. мэдээж ажиллах нөхцөл хүнд, төрийн бодлого зохицуулалт хангалтгүй дээрээс нь импортын цагаан давсыг иргэд өргөн хэрэглэдэг учраас хүнсний давсны ашиг орлого тааруу. олборлолт борлуулалттай холбоотой олон төрлийн татварууд, ордын нөөц тогтоох нарийвчилсан үнэлгээ хийлгэх тухай амхээг, мхг газруудаас тавигдах шаардлага шахалтыг жилд 10 гаруй сая төгрөгийн ашигтай давс үйлдвэрлэгчид биелүүлж чадахгүй байна. мөн тээврийн зардал болон давс олборлох хөлс өссөнөөс дотоодын давсны үнэ өсөж борлуулалтанд сөрөг нөлөө үзүүлж байна. хамгийн гол асуудал нь давсны ордуудад эрчим хүчний шугам тавигдаагүй учир олборлолтыг

механикжуулж хөдөлмөр хөнгөвчлөх, давсыг угааж цэвэршүүлэх боломжгүй. Энэ бүх асуудлыг шийдвэл одоогийн байдлаар түүхий эд хангалттай, борлуулалт хэвийн нөхцөлд улаанбаатар хотод идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг “тэгээ фүүдс” ххк болон “баялаг органик” ххк гэсэн үйлвэрүүд жилд 1500тн-3500тн иоджуулсан давс үйлдвэрлэх хүчин чадалтай байна. Үүнд орон нутгийн жижиг үйлдвэрүүдийг тооцвол манай улсын давсны жилийн хэрэгцээний 50-70% ийг дотоодоос хангах боломжтой. Хэрвээ төр засгийн зүгээс давсны үйлдвэрлэлд онцгой анхаарч, дэмжлэг үзүүлвэл үүнийг дагаад ажлын байр бий болно. Мөн иргэд, олон нийт эх орондоо үйлдвэрлэсэн чанартай, баталгаатай давсыг өдөр тутмынхаа хүнсэнд хэрэглэх ач тустай.

**-Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын 15 ордод манай улсын хүнсний давсны голлох дөрвөн орд ордоггүй? гэтэл гадны улсууд зайлшгүй ордог шүү дээ?**

Дэлхийн ихэнх улс орнууд дотооддоо давсны ордгүй бол үндэсний аюулгүй байдлын баталгаагүй улс гэж үздэг. Тиймдээ ч хүнсний давс нь стратегийн бүтээгдэхүүнд зайлшгүй тооцогддог төдийгүй улс орны стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газруудын жагсаалтад давсны ордыг оруулдаг. Би ХХААЯ-нд ажиллаж байхдаа 1999 оны “хүнсний тухай” хуулийн шинэчилсэн найруулгаар давсыг “стратегийн хүнс”-д оруулж байсан. гэтэл сүүлд 2012 оны 12 дугаар сарын 20-ны “хүнсний тухай” хуулийн шинэчилсэн найруулгаар давсыг стратегийн хүнснээс хассан байна лээ. Магадгүй давс үйлдвэрлэх асуудал одоог хүртэл шийдэгдээгүй байгаа нь энэ талын хууль эрх зүйн тогтворгүй байдалтай холбоотой. Дунд голд сүүлийн

жилүүдэд цөлжилт их явагдаж байгаа. Давс олборлоно гэдэг ганцхан ажиллах хүчнээс шалтгаалахгүй байгаль, цаг уураас шууд хамааралтай. жишээ нь манайхан дотоодод үйлдвэрлэсэн давсыг, чийгтэй, бохирдол их, том ширхэгхэгтэй гэж шүүмжлэх хандлага бий. гэтэл нуур эсвэл далайгаас давс үйлдвэрлэдэг аль ч оронд үйлдвэрийн дамжлагаар орохын өмнө чийгтэй, бохирдол их бас том ширхэгтэй байдаг.

Манайх давсны олон ордуудтай. Жишээбэл хүнсний давсны голлох дөрвөн ордоос төвтэй хамгийн ойр нь өмнөговь аймгийн дунд голын давсны орд. Улаанбаатар хотоос 901км зайтай, 421,1 мянган тн нөөц бүхий тус ордыг үйлдвэрлэл явуулахад хамгийн тохиромжтой гэж үздэг. Өмнө нь хүнсний давсны голлох ордууд ямарч эзэнгүй байсныг 1996 онд “иод дутлын эмгэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд хариуцах эзэнтэй болгосон. Төслийн хүрээнд хагас техникжсан хатаагч, бутлагч болон угаагч машиныг өгч байсан. Тухайн үед эдгээр ордуудыг хариуцаж үйл ажиллагаа явуулах эзэнтэй болгоогүй бол зарим ордууд усгаж, сүйдэхээр байсан.

**-Тоног төхөөрөмжүүд авахад хэр их хөрөнгө зарцуулагдах бол? Судалгаа байгаа юу?**

-Үйлдвэр барилаа гэхэд маш их хөрөнгө оруулалт хэрэгтэй. Давс өөрөө идэмхий биет учраас үйлдвэр явуулахад бүх металлууд нь зэвэрдэггүй ган төмөр байх ёстой. Би одоогоос арав гаруй жилийн өмнө герман, франц, голландаас зэвэрдэггүй ган төмрийн үнийг судлахад 3 сая долларын үнэтэй байсан. Хамгийн хямдхан нь гэхэд хятадын 1,5 сая долларын үнэтэй хагас механикжсэн үйлдвэр. Зөвхөн тоног төхөөрөмж гэхэд асар их өртөгтэй болно. мэдээж үйлдвэр



барьж байгаа юм чинь дэргэдээ эрчим хүчний эх үүсвэртэй байх зайлшгүй шаардлагатай. Гэсэн ч өртөг өндөр гээд бид давсаа орхиж болохгүй. Миний бодлоор хамгийн нэгдүгээрт манай улсын хүнсний давсны голлох дөрвөн орд буюу завхан аймгийн дэвтээр, увс аймгийн шүдэн уул, дорнод аймгийн сангийн далай, өмнөговь аймгийн дунд гол зэрэг ордуудыг хамгийн ойр сумаас эсвэл бүгд хилтэй ойр учир хилийн цэргээс эрчим хүчнийг шийдэх хэрэгтэй. Дараа нь үйлдвэрийн талбайд давс угаах, бутлах, хатаах машинтай болох хэрэгтэй. ингэсэн тохиолдолд хүний хөдөлмөр өмнөхөөсөө хэд дахин бага зарцуулагдаж, ажиллах хүч тодорхой түвшинд нэмэгдэнэ гэж үздэг. Би яаманд ажиллаж байхдаа энэ чиглэлээр гадны олон улс руу туршлага судлахаар явж байсан. Бүгд үйлдвэрийн тайлбайдаа ханасан уусмалтай усан сан, жижигхэн усан онгоц, транспортер буюу шугаман дамжуулагч болон бутлагч, савлагч гээд тоног төхөөрөмжтэй.

Муу нэртэй, луу данстай гэгчээр хамаг бурууг төр засаг руу чихэх нь нэг талаараа иргэдийн бэлэнчлэх сэтгэлгээтэй холбоотой. одоог хүртэл дунд голд тог цахилгаан татах асуудлаар аймаг, сумдын удирдлага, аж ахуйн нэгжүүд төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, баялгаа өөдөн татахгүй байгаа нь манай улсад давс тийм ч чухал биш мартагдсан, мартахыг хүсэж байгаа асуудал гэхэд хилсдэхгүй. гэтэл давс үйлдвэрлэлээр хөгжсөн энэтхэг, хятад, франц, бүгд найрамдах болгар зэрэг улсуудад хүний хөдөлмөрийг хөнгөвчилсэн транспортер буюу үйлдвэрийн шугаман дамжуулагч, туузан болон шанаган бутлагч, усан сан, хатаагч, савлагч, угаагч зэрэг төхөөрөмж давс олборлох талбайд нь байдаг. харин манай улсын хүнсний давсны голлох дөрвөн

ордын алинд нь ч эрчим хүч болон хөдөлмөр хөнгөвчлөх механик төхөөрөмж байхгүй. Хүрз, унадаг дугуй хоёроор давс олборлож байна. Үүнээс үүдэж зарим иргэд, аж ахуйн нэгжүүд эх орондоо үйлдвэрлэсэн давсаа чийглэг, шороотой, амт чанар сул, үнэтэй гэж шүүмжлэх тохиолдол байгааг “сондог давс”-ны цехийн эзэн с.оюунчимэг хэллээ. Гэтэл гадны улс оронд үйлдвэрийн талбайдаа эхлээд давсаа угааж, бутлана. Дараа нь хормын дотор хатааж, савлаад борлуулахад бэлэн болгодог. Манай улсад давсны үйлдвэрт ажиллах хүн олдохгүй, олдсон ч удаан хугацаанд тогтвортой ажиллахгүй байгаа асуудлыг түлхүү авч үздэг. энэ нь нэг талаараа зөв боловч манай улсад давсны чиглэлээр нарийн мэргэжилтэн бэлтгэдэг нэг ч их дээд сургууль байдаггүй юм. Гэтэл энэ үйлдвэрлэл хөгжсөн дээрх улсуудад нарийн мэргэжлийн боловсон хүчнүүд, бэлтгээд зогсохгүй давсны геологи хайгуулын болон эрдэм шинжилгээний судалгааг тогтмол хийдэг.

Сонгууль дөхөхөөр ихэс дээдсүүд “баялагтаа эзэн монгол” гэж цээжээ дэлдэн, омогшино. Яг үнэндээ залуучууд засаг төрөөс халамж хүсээгүй, үйлдвэр бариад өгөхийг шаардана. Баялагтаа эзэн байна гэдэг байгаа баялагаа өөдөн татахгүй, харь орноос гуйхыг хэлэхгүй байх. Бидний өвөг дээдэс хөршөөсөө давсаа гуйгаагүй болохоор биднийг амны хишиггүй гэж хэлэх нь аргагүй ээ. Гэтэл бодит байдал дээр гаднаас оруулж ирсэн давсыг, дотооддоо савлаж зах зээлд нийлүүлээгүй цэвэр эх орныхоо хөрс, усанд ургасан давсыг борлуулж байгаа бүх жижиг дунд үйлдвэрүүд болон өмч хувьчлалаас хойш дамдуурч, мартагдсан гэж хэлж болохоор далан жилийн түүхтэй дунд голын давсны үйлдвэрийн буурийг захиж үлдсэн арав хүрэхгүй хөгшчүүд л баялагтаа эзэн болж байна. Одоо дунд голын давсны

үйлдвэрт тэтвэрийн насны таван хүнээс өөр ажил хийх залуучууд олдохгүй байгааг үйлдвэрийн ажилчид хэллээ. Гэсэн хэдий ч үүнд ганцхан залуучуудыг буруутгаж болохгүй. Өдөр ирэх тусам технологийн хөгжил, шинэчлэл хувьсан өөрчлөгдөж байхад хүний хөдөлмөрийг хөнгөвчлөх ямар ч техник технологийгүй, гар аргаар давс олборлоно гэдэг ажиллах хүчнээс туршлага шаардагдах нь гарцаагүй. Хэн дуртай нь ирээд газрын хөрснөөс давс гаргаж чадахгүй тул залуучууд идээшихэд амаргүй. Гурвантэс сумаас дунд гол хүртэл засмал зам тавих, давсны агуулах баригдах асуудал яригддаг ч бодит байдал дээр далан жилийн өмнөхөөсөө дор байгаа нь нууц биш. энэ оны байдлаар улсын бүртгэлд давсны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 120 гаруй хуулийн этгээд бүртгэлтэй байна. бусад давсны ордуудын эзэмшил ямар байдгийг мэдэхгүй ч дунд голын давсны үйлдвэрийн талбайн 35 га-г “говь гурван сайхан ххк” авсан хэдий ч тусгай зөвшөөрөл нь цуцлагджээ. мөн “зүрийн булан” гэдэг хятад компани тус үйлдвэрийн 35га-г эзэмшдэг ба одоог хүртэл үйл ажиллагаа явуулдаггүй болохыг үйлдвэрийн ажилчин, нутгийн хөгшчүүд хэллээ.



Шуудхан хэлэхэд манай улсад давсны салбар мартагдсан гэхэд үнэнээс хол зөрөхгүй. Өөрөөр хэлбэл хүн болгоны өдөр тутамдаа өргөн хэрэглэдэг хүнсний давс нь стратегийн бүтээгдэхүүнд зайлшгүй тооцогддог учир улс орны “стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд”-д ордог болохыг дээрх эх сурвалжууд хэллээ. Харин манай улсын 2012 оны 12 дугаар сарын 20-ны “хүнсний тухай” хуулийн шинэчилсэн найруулгын нэгдүгээр бүлгийн 3.1.6 “[Стратегийн хүнс гэж](#)” [монгол хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай малын мах, сүү, тарианы үр, улаан буудай, гурил, ундны усыг](#)” хэлнэ гэж заасан байдаг. мөн стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын 15 ордын жалсаалтад манай орны хүнсний давсны голлох дөрвөн орд ордоггүй. Үүний нэг нь өмнөговь аймгийн дунд голын давсны үйлдвэр. Энэ мэтчилэн нөөц бүхий давсны ордуудыг дээрх хуулинд оруулж, төр хяналтандаа авахгүй дахиад хэдэн жил үргэлжилбэл өмч хувьчлалаас хойш дампуурч эрчимтэй үйл ажиллагаа нь зогсоод далан жил болсон дунд голын давсны үйлдвэр болон тэнд ажиллаж тэтвэрийн насны таван ажилчны түүх, түүх хэвээр үлдэх нөхцөл байдал бий болоод байна.